

**ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ**

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	хэрэгжилт	Хувь
<b>Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдал</b>			
1.1.	эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Тус төв нь өөрийн цахим хуудас болох <a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтад эрхэм зорилго, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ мэдээллийг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан, байнга шинэчилж баяжуулалтыг хийж хөтлөн явуулдаг ,	100 хувь
1.2.	чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	<a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтад байршуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100 хувь
1.3.	эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	2022 оны Санхүүгийн тайланд Аудит хийгдэж гарсан 2 зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч -Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу төвийн захирлын 2023 оны А/99 тоот тушаалаар "Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараах хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшуулал олгохдоо албан хаагчдын ажлын үр дүнгийн гүйцэтгэлийг тасаг нэгж албадын дарга нар бичгээр тайлбар бичүүлэн хүн тус бүрээр дүгнэж төвийн захирлын тушаалаар батлуулан олгож байна. -Шилэн дансны мэдээллийг шинэчилсэн хувилбарыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэн мэдээллийг хуулийн хугацаанд цаг тухай бүр шинэчлэн оруулж байна. Энэ оны эхний 11 сарын байдлаар 106 мэдээллийг оруулаад байна. Гарсан үр дүнг холбогдох байгууллагад бичгээр танилцуулж, шилэн дансанд вэб сайтанд хуулийн хугацаанд нь байршуулан ажилласан.	100 хувь
1.4.	хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хууль тогтоомж тушаал шийдвэрийн хэрэгжилтийг Эрүүл мэндийн яаманд хагас бүтэн жилээр тайлагнан ажилласан. Мөн уг тайланг <a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтад байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.	100 хувь
1.5.	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шилэн дансны хөтлөлт, Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах	100 хувь

		хөтөлбөрийн биелэлт, хэрэглэгчийн үнэлгээний тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гарган удирдах дээд байгууллагад хүргүүлэн ажилласан.	
1.6.	үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	<a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтын эрх зүйн актын хэсэгт байршуулан ажилласан.	100 хувь
1.7.	албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	<a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтад нээлттэй байдлаар байршуулан ажилласан.	100 хувь
1.8.	өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Тус төвд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 155 өргөдөл ирсэн ба тухай өргөдлүүдийг 100 хувь шийдвэрлэн өргөдөл гаргасан иргэнд хариуг хүргүүлэн ажилласан.	100 хувь
1.9.	хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Эмгэг судлалын үндэсний төв нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай” А/611 тушаалын дагуу сар, улирал, хагас, бүтэн жилээр орон нутаг, нийслэлийн дүүргүүдийн эмгэг судлалын тусламж үйлчилгээний статистик дүн мэдээг нэгтгэн ЭМХТ-д хүргүүлэн ажилласан.	100 хувь
1.10.	мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	<a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтад өөрийн төв болон дээд шатны байгуулгаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд оролцсон талаарх мэдээллийг байршуулан ажилласан.	100 хувь
Хэсгийн дундаж хувь			
Хоёр хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	<a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> болон <a href="http://www.zangia.mn">www.zangia.mn</a> мэдээллийн веб сайтуудад сул ажлын байрны зарыг байршуулан ажилласан.	100 хувь
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	<a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтад төвийн захирлын “Шинэ ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг байршуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100 хувь
2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	<a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайт болон Ёс зүйн салбар хорооны мэдээллийн самбарт “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг байршуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100 хувь
2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам	Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг <a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> сайтад байршуулан нээлттэй, ил тод болгосон.	100 хувь

2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	2023 онд тус төвд Сургалт судалгаа эрдэм шинжилгээ, гадаад харилцааны албаны дарга, Хүний нөөцийн менежер, Лабораторийн эрхлэгчийн сул орон тоо гарч <a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> , <a href="http://www.hdc.gov.mn/">http://www.hdc.gov.mn/</a> , <a href="http://Zangia.mn">Zangia.mn</a> сайтад давхардсан тоогоор 6 ажлын байрны мэдээллийг байршуулан сонгон шалгаруулалт хийж Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг хянуулан томилон ажилласан.	100 хувь
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	Тус төвийн захирлын 2023 оны А/99 дүгээр тушаалаар батлагдсан “Ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг тодорхойлох, урамшуулал олгох журмыг шинэчлэн батлах тухай” тушаалыг <a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтад байршуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100 хувь
Хэсгийн дундаж хувь			100 хувь
Гурав.Төсөв, санхүү худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухай жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл:	2022 онд 11 сарын байдлаар 1875.1 сая төгрөгийн төсөвтэй ажиллахаас 1720.0 төгрөгийн зарлагатай ажиллаж төсвийн зарлага 91.7% биелэлттэй ажилласан. 2024 оны төсвийн төслийг хамт олны хурлаар хэлэлцүүлэн ЭМЯ -нд хүргүүлэн ажилласан.	100 хувь
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан	Тайлант төсвийн орлого 271,1 сая төлөвлөгөөтэй байхаас 862,3 сая төгрөгийн орлого орж 314 хувь давж биелсэн. Төсвийн зарлага 1875,1 сая төгрөг байхаас 1720,0 сая төгрөг болж төсвийн зарлага 91,7 хувьтай байна. 2023 оны 2,3 улирлын тайланг хуулийн хугацаанд нь гаргаж СЯ-ны э-тайлан болон ЭМЯ-ны Санхүү төрийн сангийн хэлтэст гаргаж өгсөн.	100 хувь
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Өөрчлөлтгүй дүгнэлттэй гарсан ба 2023 оны аудитын дүгнэлт гараагүй байна.	100 хувь
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн Дугаар 264/ А/293 тоот “Төлбөрийн жишиг хэмжээ, журам” батлах тухай тушаалыг хэрэгжүүлэн ажилласан.	100 хувь
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт,түүний шалтгааны тайлбар	Шилэн дансны веб сайтад Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг тогтмол байршуулан хэрэгжилтийг ханган ажилласан .	100 хувь
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг	<a href="https://gap.mof.gov.mn/OrgInfo/OrgProfile">https://gap.mof.gov.mn/OrgInfo/OrgProfile</a> веб сайтад Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягыг тогтмол байршуулан ажилласан.	100 хувь
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого,	<a href="https://gap.mof.gov.mn/OrgInfo/OrgProfile">https://gap.mof.gov.mn/OrgInfo/OrgProfile</a> веб сайтад Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш	100 хувь

	зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансанд хуулийн хугацаанд нь байршуулан ажилласан.	
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түнлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авллага үүссэн аливаа шийдвэр	Бонд өрийн бичигтэй холбоотой ажил гүйлгээ гараагүй ба энэ тухай Шилэн дансны вэб сайтад байршуулсан. <a href="https://gap.mof.gov.mn/OrgInfo/OrgProfile">https://gap.mof.gov.mn/OrgInfo/OrgProfile</a>	100 хувь
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Шилэн дансны хөтлөлтийг сар, улирал, хагас, бүтэн жилээр тогтмол хуулийн хугацаанд хөтлөн хэрэгжилтийг ханган ажилласан.	100 хувь
3.10.	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	<p>ЭСҮТ-ийн 2023 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ЭМЯ, Сангийн ямаар батлуулж, хуваарийн дагуу дараах тендерийг зарласан.</p> <p>ЭСҮТ-ийн захирлын 2023.01.20-ны өдрийн “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/05 дугаар тушаалаар Эмгэг судлалын лавлагаа лабораторит 2023 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо 5 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь төрийн бус байгууллагын төлөөлөлтэй бүрэлдэхүүн томилсон. “Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах тендерийн баримт бичиг”-ийг нийт 5 багцтай боловсруулж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу тендерийг нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тендерийн урилга, үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудаст нээлттэй, ил тод байрлуулж, хэрэглэгчдийг тэгш мэдээллээр хангаж ажилласан. Худалдан авах ажиллагааны үр дүн болон нийлүүлэгч компаниудтай байгуулсан гэрээг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудаст хуулийн хугацаанд байршуулсан болно.</p> <p>Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах тендерийг 2023.01.25-нд зарласан 5 багцтай нээлттэй тендер зарлаж 4 багцад шалгарсан компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. 1 багц тендерт оролцогч компани ирээгүй тул химийн хортой бодис нийлүүлэх компанитай ерөнхий гэрээ байгуулсан.</p> <p>“Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг”-ийг боловсруулж 2023.02.14-ний өдөр үнийн санал авах урилгыг олон нийтэд цахим хуудсаар ил тод зарласан. Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан цахимаар зарлах тендерийн төсөвт өртөгөөс бага буюу 19.4 сая.төгрөг тул харьцуулалтын аргаар уг арга хэмжээг зохион байгуулсан.</p>	100 хувь

		<p>Үнийн санал хүлээн авахаар заасан хугацаанд зөвхөн нэг компани материалаа ирүүлж, шаардлага хангасан тендер учир гэрээг байгуулсан.</p> <p>2023 онд Ерөнхий гэрээгээр худалдан авах эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад багтсан 4 нэр төрлийн бараа материалыг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим дэлгүүрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: малгай, амны хаалт, халад, улавчны 3-р улиралд ашиглах бараа материалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу тендерийг нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тендерийн баримт бичгийг боловсруулах, цахим хэлбэрээр зохион байгуулах, худалдан авах ажиллагааны үр дүн болон нийлүүлэгч компаниудтай байгуулсан гэрээг цахим хуудаст байршуулсан.</p>	
3.11.	худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	<p>ЭСҮТ-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдэж байгаа бөгөөд хараахан дүгнэлт гараагүй болно. 2022 оны санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлтээр “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан. ЭМЯ-с ЭСҮТ-ийн санхүүгийн үйл ажиллагааг “хангалттай сайн буюу 95А” гэж үнэлсэн.</p>	100 хувь
3.12.	мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	<p>ЭСҮТ-ийн захирлын 2023.01.25-ны өдрийн А/05 дугаар тушаал /эм, эмнэлгийн хэрэгсэл/, /иммуногистохимийн урвалж/-аар тус тус томилогдсон үнэлгээний хорооны гишүүд нь худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн А3 гэрчилгээтэй байсан.</p>	100 хувь
3.13.	төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	<p>ДЭМБ-ын санхүүжилтаар Эмгэг судлалын ирээдүйн чиг хандлага, хөгжлийн гарц төслийг улсын хэмжээнд зохион байгуулсан.</p>	100 хувь
3.14.	мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	<p>2023 онд захиалгаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажил байхгүй болно.</p>	100 хувь
3.15.	Хууль тогтоомжид заасан бусад	<p>Төсөв санхүү худалдан авах ажиллагааны талаарх хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэн ажилласан.</p>	100 хувь
Хэсгийн дундаж хувь			100 хувь
Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн			
4.1.	үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	<p>Эмгэг судлалын тусламж үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, төсвийн харилцах дансны мэдээллийг <a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайт болон үйлчлүүлэгчид мэдээлэл өгөх самбарт байршуулан ажилласан.</p>	100 хувь
4.2.	Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн,	<p>Тус төв нь оргүй төвийн бүтэцтэй тусгай мэргэшлийн төв учир тусгай зөвшөөрөл олгодоггүй болно.</p>	

	хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа		
Хэсгийн дундаж хувь			100 хувь
Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	2023 онд Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа захиргааны хэм хэмжээний актын төсөл байхгүй болно.	
5.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	Монгол Улсын Оюуны Өмчийн Газрын Даргын 2021.03.25-ны өдрийн А/25 дугаар тушаалаар “Эх хүүхдийн эмгэг судлалын мэргэжил дээшлүүлэх зайн сургалт” болон Монгол Улсын Оюуны Өмчийн Газрын Даргын 2021.03.25-ны өдрийн А/25 дугаар тушаалаар “Умайн хүзүүний эсийн шинжилгээний оношилгооны чадамж сайжруулах интерактив сургалт”, Монгол Улсын Оюуны Өмчийн Газрын Даргын 2021.05.18-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар “Эдийн макро шинжилгээний арга техникийн интерактив сургалт” оюуны эрхийг тус тус эзэмшиж байгаа болно.	100 хувь
5.3.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл		Байхгүй
5.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл		Байхгүй
5.5.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэжээ, ноогдол ашиг	Тус төв нь оргүй төвийн бүтэцтэй тусгай мэргэшлийн болно.	
5.6.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон	Тус төв нь оргүй төвийн бүтэцтэй тусгай мэргэшлийн болно.	

	шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл		
5.7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	Байхгүй	
5.8.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл,	Тус төвийн тусламж үйлчилгээ нь байгаль орчинд нөлөөлөл үзүүлдэггүй болно.	
5.9.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	Байхгүй	
5.10.	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	Байхгүй	
5.11.	Нэвтрэх ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл	<a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтад “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” болон “Байгууллагын нууцын тухай” хуульд заагдсан нууцлалын мэдээллээс бусад мэдээллийг нээлттэй байршуулан ажилдаг.	100 хувь
5.12.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	Тус төвийн зардлаар гадаад улс болон дотоодод суралцаж байгаа мэргэжилтэн байхгүй болно.	100 хувь
5.13.	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	<a href="http://pathology-center.gov.mn/">http://pathology-center.gov.mn/</a> веб сайтад “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” болон “Байгууллагын нууцын тухай” хуульд заагдсан нууцлалын мэдээллээс бусад мэдээллийг нээлттэй байршуулан ажилдаг.	100 хувь
Хэсгийн дундаж хувь:			
Хэрэгжилтийн дундаж хувь:			

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:  
ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ГАНХҮҮ

ХЭРЭГЖИЛТИЙГ БОЛОВСРУУЛСАН:  
Бодлого, төлөвлөлтийн албаны дарга

Б.Ариухантөмөр